

хөндөх сэдэв

# Монгол Улс усны хомсдолд ороход ойрхон байна

-Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас гаргасан мэдээгээр дээрх аюул манай орныг арваадхан жилийн дараа нөмрөнө. Ингэснээр монголчууд хэрэглээний усаар гадаадаас харьяат болж, өөрсдөдөө нэг том бэрхшээл нэмэх нь-

**З**амын-Үүдийнхэн урд хөршөөс орж ирсэн цэвэр усаар аяганы амсар зуудаг болсоор нэлээд удаж буй аж. Учир нь хэрэгцээг нь хангаж буй усны хатуулаг хэрээс хэтэрсэн тул арга буюу ийн амь зуухад хүрчээ.

Тэндхийн оршин суугчийн өгүүлснээр зарим наймаачин арилжаа наймаагаа өөрчилж, "гахай" зөөхийн оронд ус дүүрдэг болсон. Нэг талдаа энэ нь ашиг хонжоо бодсон наймаачдын сүйсээ гэж хэлж болох ч цаад утгаараа, Монгол Улс усны хомсдолд орсны нэгэн тод жишээ аж.

Усны хомсдол ингэхэд Замын-Үүдээр зогсох болов уу. Ийм асуулыг мэргэжлийн байгууллагуудад тавибал толгой сэгсэрч байна. Харин ч цааш улам хүрээгээ тэлэх гэнэ. Үүнд эхний ээлжинд Монгол орны хамгийн өмнөд хэсэг болох говийнхон өртөж, дараа нь усаар барагтай бол хатдаггүй Хангайханд нүүрлэх ажээ.

Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас гаргасан мэдээгээр дээрх аюул манай орныг арваадхан жилийн дараа нөмрөнө. Ингэснээр монголчууд хэрэглээний усаар гадаадаас харьяат болж, өөрсдөдөө нэг том бэрхшээл нэмэх нь.

Ер нь ч манай орон дэлхийд усны нөөцөөр тийм ч толгой цохидоггүй юм байна. Бид л өөрсдөө цээжээ дэлдэж баярхдаг болохоос биш.

Дэлхийн байгаль хамгаалах сангаас хийсэн судалгаагаар Монгол Улс усны нөөц багавтар гэсэн ангилалд бүртгэгджээ. Тодруулбал, дэлхийн 145 орноос 22-т жагссан юм байна. Арваад

жилийн дараагаар харин энэ жагсаалт бүр хойшоо ухарч сүүл мушгиах үгүйсгэхгүй. Учрыг нь дээр тайлбарласан шүү дээ.

Манай улс уг нь Өмнөд Африк, Индонези зэрэг орныг бодвол гадаргын усны нөөцөөрөө баянд орно. Гэтэл яагаад хөршөөсөө царайчлахад хүрээ. Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын ус зүйч Н.Батнасангийн өгүүлснээр үүнд цаг уурын дулаарал гол нөлөө үзүүлжээ. Дээр нь хүний буруутай үйл ажиллагаа нэрмээс болсон гэнэ. Тэр дундаа алтны манатуудын "хувь нэмэр" их. Алтаа л авч байвал нөхөн сэргээлт хамаагүй. Дээр нь өнөөх ухсан алтаа ойролцоох гол мөрөнд угаадгаас ус мөрөн булингартаж загас жараахайг амьдрах орчингүй болгодог аж. Мөн оршин суугаа иргэд ч усны үсгүй болдог байна.

Сүүлийн таван жилд гэхэд л Монгол орны хэмжээнд дээрх үйл ажиллагаатай холбоотойгоор 683 гол горхи, 1484 булаг шанд, 760 нуур цөөрөм ширгэжээ.

Одоогоор Монгол орны гадаргын усны нөөцийн 83.7 хувийг нуур, 10.5 хувийг мөсөн гол, 5.8 хувийг голын ус бүрдүүлж буй гэнэ.

Ийм үед харин усан цахилгаан станцыг барьж буй нь хэр оновчтой юм бол.

Энэ асуултад хариулт олохыг хичээлээ.

Хүн бүр одоо Ховд аймгийн Дөргөн сумын нутагт орших Чоно харайхын гол дээр баригдаж буй усан цахилгаан станцыг хэзээ ашиглалтад орох бол гэж тэсч ядан хүлээж сууна. Арга ч үгүй биз, дээрх усан цахилгаан станц ашиглалтад



Ер нь ч манай орон дэлхийд усны нөөцөөр тийм ч толгой цохидоггүй юм байна. Бид л өөрсдөө цээжээ дэлдэж баярхдаг болохоос биш. Дэлхийн байгаль хамгаалах сангаас хийсэн судалгаагаар Монгол Улс усны нөөц багавтар гэсэн ангилалд бүртгэгджээ. Тодруулбал, дэлхийн 145 орноос 22-т жагссан юм байна.

ороход Монгол орны баруун хязгаар эрчим хүчний хувьд ОХУ-аас хараат бус болох юм чинь. Гэхдээ л энхаарах зүйл их аж. Учир нь УЦС-ын сөрөг нөлөө их юм

байна. Усан цахилгаан станцын далан барьсан газрын нуурын эрэг нурдаг. Улмаар булингартаж, гол мөрний усны хэвийн урсгал алдагддаг гэнэ. Гол мөрний усны

төвшин огцом хэлбэлздэг. Түүгээр ч үл барам голын усны дээд бүлээссэн хэсэг нь гүний хүйтэн устай холилдож чадахгүйгээс хүчилтөрөгчөөр хомсдож, тэнд

амьдрах загас жараахайг амьдралгүй болдог байна. Сөрөг нөлөө үүгээр хязгаарлагдахгүй хүчилтөрөгч багатай ус хад чулуунд агуулагдсан зарим нэг элементтай урсгалд орж далангаас доошхи ус руу урсан байгаль орчныг ихээр бохирдуулдаг гэж байгаа. Тийм учраас хөгжилтэй орнууд сүүлийн жилүүдэд усан цахилгаан станц барихыг тэр бүр чухалчлахаа больжээ. Барьдаг юм аа гэхэд түүнээс урьтаж сөрөг нөлөөллийг хамгийн түрүүнд чухалчилж үздэг аж. Энэ нь чухамдаа алсаа бодсон бодлого бөгөөд усны хомсдлоос зайлсхийсэн арга аж.

Манайх ч уг нь энэ журмаар ажилласан юм билээ. Судалгааг ХБНГУ-ын "Вайсер энд Несс" компани, Монголын ШУА-ийн зарим эрдэмтэдтэй хамтран хийсэн. Тэд УЦС-ын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судалдаг туршилагатай эрдэмтэд байсан бөгөөд УЦС барих хөтөлбөрт болгоомжтой хандахыг анхааруулжээ. Мөн Итгэлт-Аудит ХХК-ийнхэн эдийн засаг талаас нь судалгааг хийсэн. Тэдний судалгаагаар Дөргөний усан цахилгаан станцын гаргах 1 км/цаг цахилгааны үнэ нь ОХУ-аас авч байгаа цахилгааны үнээс өндөр байх болно гэсэн тооцоог гаргасан явдал. Чухамдаа хэрэглэгч, үйлдвэрлэгчийн хооронд бэрхшээл үүсч болохыг анхааруулсан хэрэг л дээ. Гэвч Монгол Улсын Засгийн газар санасандаа хүрч хөтөлбөрт тусгаснаа хэрэгжүүлж буй.

Хожим гарах үр дагаврыг нь сайтар тооцоолсон байгаасай л гэж найдахаас...

Г.НЭРГҮЙ